




Увс аймаг дахь төрийн аудитын газар

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай
хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитын
хураангуй тайлан



Улаангом 2023 он

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн
хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудит.



01


Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх.

02

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжсэн эсэх.

03

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авсан эсэх.



Монгол улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх чиглэлээр дэвшүүлсэн арга хэмжээтэй уялдуулан "Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Аймгийн 2021, 2022 онд хөгжүүлэх үндсэн чиглэл", "Хоёр живаа харгаа" хөтөлбөр зэрэг дунд болон, богино хугацааны баримт бичгүүдэд холбогдох зүйл, заалтуудыг тусгаж аймгийн ИТХ-аас баталсан байна.

Газар зохион байгуулалт, ан агнуур, усны нөөцийн менежментийн төлөвлөгөө

01


Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2016 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/150 дугаар тушаалаар Увс нуур-Тэс голын сав газрын Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө.

02

Аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/167 дугаар тогтоолоор 2019-2024 оны аймгийн "Нарийвчилсан ан агнуурын менежментийн төлөвлөгөө.

03

Аймгийн ИТХ-ын 2014 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 8/06 дугаар тогтоолоор "Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тус бүр батлуулсан байна.



Харин аймаг болон сумдын ойн менежментийн төлөвлөгөөг батлуулаагүй байсан. Цаашид аймаг болон сумдын ойн менежментийн төлөвлөгөөг батлуулан ажиллахыг зөвлөмж болгосон.

Аймгийн "Ургамалын менежментийн төлөвлөгөө"-г боловсруулж батлуулаагүй байна. Уг асуудлыг Байгалийн ургамлын тухай хуульд менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулах талаар тодорхой заалт тусгуулах саналыг Үндэсний аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлэв.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл

2021 он

2022 он

Орлогын төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
Газрын нөөцийн төлбөр	680.0	593.6	86.4	750.0	661.3	88.7
Ус, рашааны нөөцийн төлбөр	40.0	53.5	-13.3	40.0	42.7	-2.7
Ан амьтны нөөцийн төлбөр	5.0	445.6	-440.6	520.4	614.8	-94.4
Ойн нөөцийн төлбөр	71.5	202.5	-131.0	85.5	171.5	-86.5
Дүн	796.5	1,295.0	-498.5	1,395.4	1,490.3	-94.9



Дээрх хүснэгтээс харахад ан амьтны нөөц ашигласны төлбөр 2021 онд 89 дахин, ойн нөөц ашигласны төлбөр 3 дахин давж биелсэн, 2022 онд ойн нөөц ашигласны төлбөр 2 дахин давж биелсэн нь орлогын төлөвлөгөөг үндэслэл муутай төлөвлөснийг илтгэж байна. Цаашид Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийг үндэслэлтэй хийж байхыг зөвлөмж болгосон.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардалд 2021 онд 44 арга хэмжээнд 347.4 сая төгрөг, 2022 онд 69 арга хэмжээнд 642.9 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байсан.



Байгалийн нөөц ашигласны төлбөрийн зардлын гүйцэтгэлийг дутуу мэдээлсэн байна.



Зардлын гүйцэтгэлийн 2022 оны мэдээг тулгахад байгалийн нөөц ашигласны төлбөрийн нийт орлого 223.4 сая төгрөгөөр дутуу, байгалийн нөөцөд зарцуулах нийт зардлыг 4.1 сая төгрөгөөр илүү, нийт зардлын гүйцэтгэлийг 98.1 сая төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Үзүүлэлт	Төлбөрийн орлого	Зарцуулалт	зөрүү
EIC.mn /finance/	1077.6	646.9	496.5
Аудит	1301.0	642.8	398.4
Зөрүү дүн	(223.3)	4.1	98.1



Цаашид eic.mn/finance/ цахим системд Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулж байхыг зөвлөв.

Байгалийн нөөц ашиглалтын төлбөрийн орлогын талаарх тоо мэдээлэл хоорондоо зөрүүтэй байгаа нь төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сул байгааг харуулж байна. Цаашид аймгийн төрийн захиргааны байгууллагуудын уялдаа холбоог сайжруулан ажиллахыг зөвлөв.

Байгууллага	2021 он	2022 он
СТСХэлтэс	593.6	562_3
ГХБХБГ	501.8	536.4
Татварын хэлтэс	536.4	534..4



Аудитаар өгсөн зөвлөмж

Сумын ИТХ-ын дарга нарт: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу хяналт шалгалтыг хийж байх.

Аймгийн Засаг даргад: Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөгөө батлуулан ажиллах.

Сумдын Засаг дарга нарт: Ой бүхий сумд ойн менежментийн төлөвлөгөөгөө батлуулан ажиллах.

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргад:
1. Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг журмын дагуу хэрэгжүүлэх.

2. Ойн ангиудын үйл ажиллагаанд тавих шат шатны хяналтыг сайжруулах.

Түргэн сум дахь Сум дундын ойн ангийн даргад: "Улаангом суманд хамгаалалтын ойн зурвас байгуулах" ажлыг бүрэн хийж гүйцэтгэх.

Үндэсний аудитын газарт: Байгалийн ургамлын тухай хуульд менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулах талаар тодорхой заалт оруулахыг ҮАГ-ын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлэв.

Дэлгэрэнгүй мэдээлэл, аудитын тайланг www.open.audit.mn хуудаснаас аваарай анхаарал хандуулсанд баярлалаа.